

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Прокурорын газрын 2021 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** ДАА-2022/121/НА-СА-ТШЗ

Цахим хуудас:

[www.audit.mn](http://www.audit.mn)

Дархан-Уул аймаг

2022 он

Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудиторын албан үүргийн түр орлон гүйцэтгэгч:  
Ш.Мөнхбаяр

Утас: 70378845 Цахим хаяг: [munkhbayarsh@audit.gov.mn](mailto:munkhbayarsh@audit.gov.mn)

Ахлах аудитор: С.Батцэцэг

Утас: 70373089 Цахим хаяг: [battsetsegs@audit.gov.mn](mailto:battsetsegs@audit.gov.mn)

Ахлах аудитор: Х.Сувдмаа

Утас: 70373089 Цахим хаяг: [Suvdmaakh@audit.gov.mn](mailto:Suvdmaakh@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу



**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

49259 Дархан-Уул аймаг  
Дархан-Уул, 14-р баг  
Утас: 7027-3085, факс: 075 7027-3089  
E-mail: darhanul@audit.gov.mn

2021.02.11 № 65

Танай \_\_\_\_\_ -нээ Аг \_\_\_\_\_ -д

ПРОКУРОРЫН ТАМГЫН ХЭЛТЭСИЙН ДАРГА  
Б.БАТЖАРГАЛ ТАНАА



**АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ**

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 6.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5.1-д заасны дагуу Дархан-Уул аймгийн Прокурорын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хоронголомчийн өөрчлөлт, мөнгөн гүйцэтгэлийн тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дархан-Уул аймгийн Прокурорын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журим, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдсан этгээдээс харааг бус, аудиторын өс зүйн үүрэг хариуцлагыг биелүүгч ажигласан. Бидний дүгнүүлсэн хангалттай бөгөөд эхистэй нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж хэрэглүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангад эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН  
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Ш.МӨНХБАЯР



009020049

## Нэг. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

(төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	2020.12.31	2021.12.31
<b>Санхүүгийн байдлын тайлан</b>			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	13,648,927.00	14,679,599.00
	Бараа материал	13,648,927.00	14,679,599.00
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	774,622,067.48	157,989,186.04
	<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>788,270,994.48</b>	<b>820,079,380.63</b>
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	788,270,994.48	820,079,380.63
	<b>Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>788,270,994.48</b>	<b>820,079,380.63</b>
<b>Санхүүгийн үр дүнгийн тайлан</b>			
	Үйл ажиллагааны орлогын дүн	759,728,078.31	893,305,788.00
	Үйл ажиллагааны зардлын дүн	763,597,496.88	861,497,401.85
	<b>Үйл ажиллагааны үр дүн</b>	<b>(3,869,418.57)</b>	<b>31,808,386.15</b>
	Үйл ажиллагааны бус үр дүн	-	-
	<b>Үйл ажиллагааны нийт үр дүн</b>	<b>(3,869,418.57)</b>	<b>31,808,386.15</b>
<b>Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан</b>			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	986,906,485.52	788,763,794.48
	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт		(492,800.00)
	Тайлант оны үр дүн	-	31,808,386.15
	<b>Эцсийн үлдэгдэл</b>	<b>986,906,485.52</b>	<b>820,079,380.63</b>
<b>Мөнгөн гүйлгээний тайлан</b>			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	675,845,600.00	847,175,100.00
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	675,845,600.00	811,991,600.00-
	<b>Үйл ажиллагааны ЦМГ</b>	-	<b>35,183,500.00</b>
	<b>Хөрөнгө оруулалтын ЦМГ</b>	-	<b>(35,183,500.00)</b>
	<b>Санхүүгийн ажиллагааны ЦМГ</b>	-	-
	<b>Нийт цэвэр мөнгөн гүйлгээ</b>	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-
<b>Төсвийн гүйцэтгэлийн тайлан</b>			
	<b>Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн</b>	<b>843,195,100.00</b>	<b>810,570,931.73</b>
	<b>Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр</b>	<b>843,195,100.00</b>	<b>810,570,931.73</b>
	Улсын төсвөөс санхүүжих	843,195,100.00	810,570,931.73

### Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Прокурорын газар нь прокурорын бүрэн эрх, үйл ажиллагааны зарчим, баталгаа, прокурорын байгууллагын тогтолцоо, зохион байгуулалт, бие даасан байдлыг хангах зорилтын дор 5 чиг үүргийг хэрэгжүүлж байна.

### Гурав. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Төсвийн шууд захирагч үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал, санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

### Дөрөв. Аудитын гол асуудал

Улсын бүртгэлийн хэлтсийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудал байхгүй.

### Тав. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн 6 дугаар зүйлд заасантай нийцсэн байна гэж дүгнэлээ.

## Зургаа. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц чухал асуудал байхгүй болно.

### Долоо. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 72,708.1 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрсэнд 63,647.7 мянган төгрөгийн алдааг залруулж, 9,154.4 мянган төгрөгийн 1 зөвлөмж өгсөн.

#### 4.1 Залруулсан алдаа

Санхүүгийн үр дүнгийн тайлангийн өмнөх оны үр дүнгийн тайланг 63,647.7 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасныг залруулав.

#### 4.2 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоох зөрчилтэй асуудал гараагүй болно.

#### 4.3 Албан шаардлага

Албан шаардлага хүргүүлэх зөрчилтэй асуудал гараагүй болно

#### 4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

### 1. *Шатахууны зардлын данстай холбоотой асуудал*

#### 1.1. Илрүүлэлт:

Тус газрын тайлант оны авто машины замын хуудасны бичилтийг гүйцэтгэсэн ажил үйлчилгээтэй тулган шалгахад спидометрийн заалтыг бичээгүй, 9,154.4 мянган төгрөгийн шатахууны тооцоог бодоогүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна”, 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

#### 1.2. Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6, 13.7 дахь заалтуудыг баримталж, жолоочийн замын хуудсанд ирсэн, явсан цаг, спидометрийн заалтыг нэг бүрчлэн бичүүлж, нягтлан бодогч шатахууны тайланг тооцоо бодсон актаар үйлдэж байх

### 7.1 Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан		Аудит хийгээгүй	7	8				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
	<b>НИЙТ</b>	<b>1</b>	<b>1</b>			<b>1</b>			

**7.2 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:**

(сая төгрөгөөр)

№	Төсвийн захирагчийн ангилал	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
A	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
1	ТШЗ	2	72.8	1	63.6	-	-	-	-	1	9.2
	<b>НИЙТ</b>	<b>2</b>	<b>72.8</b>	<b>1</b>	<b>63.6</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>9.2</b>